



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/9/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.3 Авлага	8
2.8.4 Урьдчилгаа	8
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.6 БАРАА МАТЕРИАЛ	8
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	10
2.9 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

1. Аудитын гэрчилгээ

		ХӨЛӨНБУЙР СУМЫН ЗАСАГ ДАРГА У.ГАНХУЯГ ТАНАА
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР		
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203		
<i>2020.03.25</i> № <i>330</i>		
танай	-ны №	-т
Аудитын гэрчилгээ		
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөлөнбуйр сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.		
Зөрчилгүй санал дүгнэлт		
Хөлөнбуйр сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.		
Санал дүгнэлтийн үндэслэл		
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.		
Аудитаар Хөлөнбуйр сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.		
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.		
110520272		



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч У.Ганхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөлөнбуйр сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж гүйцэтгэв.

Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/77 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөлөнбуйр сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Хөлөнбуйр сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Хөлөнбуйр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөлөнбуйр сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 2,106.3 сая төгрөгийн 2 хувь буюу 42.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 51.4 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллага аудитад хамрагдсан.



Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 6 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, 3 байгууллагын тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

- Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 35,583.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, сум хөгжлийн сангийн зээлийн хүүгийн авлагыг бүртгэхдээ хүү, алдангийн орлогын 5,311.2 мянган төгрөгийг тусгаагүй алдааг аудитын явцад залруулж, 272.2 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж 30,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 78.599.4 мянган төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- Хөлөнбуйр сумын Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ: санхүүгийн тайлангийн тулгалтаар өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнг 555,3 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байсныг санхүүгийн тайланд залруулсан.
- Хөлөнбуйр сумын ЗДТГ: Тайлант онд сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 33,000.0 мянган төгрөгийн хогны машин, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлж гүйцэтгэсэн 4,780.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн "Нүхний булгийн эхний хашаажуулалт"-ыг хөрөнгийн орлогоор бүртгээгүй байсныг хөрөнгөд орлогод тусгуулан санхүүгийн тайланд залруулсан
- Хөлөнбуйр сумын ЗДТГ: Хадлангийн барьцаа хөрөнгийн орлого 22,700.0 мянган төгрөг, малын эмчийн тарилга хийхээр явсан шатахуун болон бусад зардал 2,212.7 мянган төгрөгийн зардлыг бууруулах бичилт хийсэнд санхүүгийн тайланд залруулсан.
- Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төв: Үнэ төлбөргүй ирсэн 4 нэр төрлийн 6,123.1 мянган төгрөгийн эмийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулсан.
- Хөлөнбуйр сумын Соёлын төв: Хөрөнгийн тулгалтаар бараа материалын дансанд бүртгэлтэй 9,228.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг, үндсэн хөрөнгийн дансанд тусгуулж санхүүгийн тайланд залруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 170,450.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 142,848.6 мянган төгрөг болж 27,602.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн банканд байгаа мөнгө	170,124.6	139,656.9	-30,467.7	-82.0
Арилжааны банканд байгаа мөнгө	326.1	3,191.8	2,865.6	78,7



Замд яваа мөнгөн хөрөнгө

Хадгаламж

Дүн	170,450.7	142,848.6	-27,602.1	16.2
------------	------------------	------------------	------------------	-------------

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 142,848.6 мянган төгрөгөөс төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 139,656.9 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 3,191.8 мянган төгрөг байршиж байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 410,655.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 277,019.9 мянган төгрөг болж, 133,635.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	127,955.8	32,371.3	-95,584.5
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээл, зээлийн хүүгийн авлага	203,124.7	214,292.3	11,167.6
Бусад авлага	79,575.3	30,356.3	-49,219.0
Зээлийн авлага			
Дүн	410,655.8	277,019.9	-133,635.9

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 214,292.3 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн 1 жилийн насжилттай 168,642.7 мянган төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 3-4 жилийн насжилттай 21,696.4 мянган төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 5-аас дээш жилийн насжилттай 23,953.2 мянган төгрөгийн авлага байна.

Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү болон алдангийг сумаас мэдэгдэх хуудас өгөх болон шүүхэд шилжүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Зээлийн төлбөрөө хугацаандаа төлөөгүйн улмаас дараа дараагийн зээлийн олголтод сөрөг үр дагавартай байна.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс үлдэгдэлгүй байна.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 317,693.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 341,683.0 мянган төгрөг болж 24,019.6 мянган төгрөгөөр өссөн байна.



Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	139,271.1	164,099.0	24,827.9
Түүхий эд материал	1,170.6	345.8	-824.8
Мал	177,251.5	177,268.1	16.5
Дүн	317,693.5	341,683.0	24,019.6

Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,721,362.8 мянган, эцсийн үлдэгдэл 8,283,332.5 мянган төгрөг болж, 561,969.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,602,452.8	8,164,422.5	561,969.7
Биет бус хөрөнгө	118,910.0	118,910.0	
Дүн	7,721,362.8	8,283,332.5	561,969.7

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 47,084.6 мянган, балансаас балансад шилжүүлэн авсан 460,769.6 мянган, үнэ төлбөргүй хандиваар авсан 54,115.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөрөнгө хасагдаагүй байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 95,555.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 31,931.7 мянган төгрөг болж 63,623.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөр /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>				
ЗДТГазар	43.5	0	-43.5	
ЕБСургууль	1,134.6	0	-1,134.6	
Цэцэрлэг	1,967.2	0	-1,967.2	
ЭМТөв	90.0	0	-90.0	
ОНХСан	11,906.8	1,439.0	-10,467.8	
Соёлын төв	599.1	56.0	-	
			543.1	
ХБ хөгжил	238.8	79.5	-159.3	
Нэмэлт данс	79,575.3	30,356.2	-49,219.1	
Дүн	95,555.3	31,931.7	-63,623.6	

Богино хугацаат өр төлбөрийн нийт үлдэгдэлд 31,931.7 мянган төгрөг байгаа бөгөөд үүнээс ЗЗБУХМ-ийн төслийн үлдэгдэл 16,000.0 мянган төгрөг, хашаажуулалтын эргэн төлөлт



5,612.7 мянган төгрөг, үлийн цагаан оготно устгалын 5,478.0 мянган төгрөг, хадлангийн буцаан олгох төлбөр 3,266.5 мянган төгрөг, бусад харьяа байгууллагуудад өгөх 1,574.5 мянган төгрөгийн өр төлбөр байна.

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,240,241.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7,404,000.0 мянган төгрөг болж 163,759.1 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалттай холбоотой.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,501,541.9	1,501,541.9		
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	4,699,162.8	4,862,921.9	163,759.1	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,039,536.3	1,039,536.3		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	7,240,241.0	7,404,000.0	163,759.1	

Засгийн газрын оруулсан капитал данс болон хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү өөрчлөгдөөгүй.

2.9 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2018 оны орон нутгийн төсөв батлах тухай 06 дугаар тогтоолд зааснаар тайлант онд 45,200.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 81,470.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 180,2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	2,000.0	15,196.2	13,196.2	759,8
Шууд бус орлого	15,000.0	15,030.9	30.9	100,2



Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бууны албан татвар	3,200.0	2,200.0	1,000.0	68,7
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	3,917.7	-1,917.7	195,8
Хог хаягдлын хураамж	2,000.0	2,176.2	176.2	108,8
Хадгаламжийн хүүгийн орлого	7,500.0	10,458.9	2,958.9	139,4
Торгуулийн орлого	12,000.0	23,781.0	11,781.0	198,2
Бусад орлого	1,500.0	8,709.5	3,509.5	580,6
Нийт дүн	45,200.0	81,470.5	30,735.0	180,2

Нийт орлого 30,735.0 мянган төгрөгөөр давсан нь хүү торгуулийн орлого, хадгаламжийн хүүгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,605,182.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,440,402.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 115,300.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 49,480.0 төгрөгийг, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 892,555.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 541,214.2 мянган төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18,464.1 мянган төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгийг, СХС-гаас 50,230.0 мянган төгрөгийг, ОНХС-гаас 101,718.1 төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 892,555.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 541,214.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан бөгөөд ОНХС-гаас 101,718.1 мянган төгрөгийг СХС-гаас 48,818.9 мянган төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт нь гүйцэтгэлээрээ буюу 12,178.1 мянган төгрөг олгогдож СХС-гийн эргэн төлөлтөөс 2,411.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын 6,286.0 мянган төгрөгөөр нийт 8,697.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,550,181.5 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь ажиллагсдын орон тоо дутуу, хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй, түлш халаалтын зардал хэмнэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээнд 115,300.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан. Урд оны үлдэгдлээс 18,289.1 мянган төгрөгийг, ОНХС-гаас 83,000.0 мянган төгрөгийг, үйл ажиллагааны орлогоос 14,350.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, 79,487.1 мянган төгрөгийг хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд зарцуулж, 30,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэлгүй үлдсэн байна. ОНХС-гийн дансанд 36,152.0 мянган төгрөг үлдсэн байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсвийг Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгө/-гаас 5,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 154,698.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 30,328.5 мянган төгрөг, нийт 190,026.6 мянган төгрөгийн орлогоос бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин, НДШ-д 7,853.3 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 2,099.1 мянган төгрөгийг, нормативт зардал 80.0 мянган төгрөгийг, урсгал зардал 26,398.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1,038.1 бараа үйлчилгээний бусад зардалд 40,976.5 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 81,224.6 мянган төгрөгийг, нийт 159,670.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 30,356.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Сумын Засаг дарга нар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс, журамд зөвшөөрөгдөөгүй арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай.



2.11. Шилэн дансны мэдээлэл:

Хөлөнбуйр сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллийн 135 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд: Хөлөнбуйр хөгжил ОНӨААТҮГ нь 1-3 сарын мэдээллийг хоцроосон байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төсвийг батлахдаа сумын ИТХ-ын хурлын тогтоолд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тусгаж байх гэсэн албан шаардлага өгч, дээд шатны захирагчийн зөвшөөрөлгүй хандив тусламж авсныг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлсэн.

Нийт өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж 2019 оны 06 сарын 19-ний 1/354 тоотор хүргүүлж ажилласан байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөлөнбуйр сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Засаг даргын нөөцийн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс мөрийн хөтөлбөрт тусгагдсан гэсэн үндэслэлээр журамд заагдаагүй арга хэмжээнд зарцуулсан байна.

3.1.2 Эрсдэл: Хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтыг мөрдөн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.1.5 Илрүүлэлт: ОНХС-гийн хөрөнгөөр 115,300.0 мянган төгрөгийн 10 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр батлагдсанаас, компани татгалзсан 28,000.0 мянган төгрөгийн худгийн ажил, тендерт оролцогч ирээгүй соёлын төвийн дээврийн ажлын 2,000.0 мянган төгрөгийн ажлууд нь тайлант онд хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 41.2, 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.6 Эрсдэл: Хөрөнгө оруулалтын үр ашиг буурах.

3.1.7 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллах.

3.1.8 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.1.9 Илрүүлэлт: ИТХ нь нийт худалдан авалтын 4,4 хувь буюу 272.2 мянган төгрөгийн е-баримтыг анхан шатны баримт болгон хавсаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 дахь заалт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм." гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.10 Эрсдэл: Хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах.

3.1.117 Өгсөн зөвлөмж: Хууль журмыг мөрдөн ажиллах.



3.1.8 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	898 799 995,51	761 551 668,54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	170 450 695,53	142 848 717,17
3121	Төгрөг	170 450 695,53	142 848 717,17
31211	Төрийн сангийн харилцах	170 124 576,64	139 656 952,35
31213	Арилжааны банк дахь харилцах	326 118,89	3 191 764,82
33	АВЛАГА	410 655 841,13	277 019 920,64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	723 485,39	153 248,34
33400	Зээлийн хүүгийн авлага		5 311 209,78
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	71 436,30	15 555,30
335	Бусад авлага	409 860 919,44	271 539 907,22
3351	Байгууллагаас авах авлага	160 368 030,44	30 382 192,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	249 492 889,00	241 157 715,22
35	БАРАА МАТЕРИАЛ	317 693 458,85	341 683 030,73
351	Түүхий эд материал	3 325 232,34	1 361 403,72
35130	Эм боох материал	3 325 232,34	1 361 403,72
354	Хангамжийн материал	137 116 757,51	163 053 533,01
35410	Бичиг хэргийн материал	6 444 150,70	7 520 750,70
35420	Аж ахуйн материал	97 769 091,76	106 963 179,76
35440	Түлш, шатах тослох материал	14 771 978,00	8 236 680,00
35460	Хүнсний материал	1 170 686,05	345 871,55
35470	Бусад хангамжийн материал	16 960 851,00	39 987 051,00
35600	Мал амьтад	177 251 469,00	177 268 094,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6 436 999 288,38	6 674 383 168,40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6 436 999 288,38	6 674 383 168,40
392	Биет хөрөнгө	6 316 512 288,18	6 552 815 188,18
39201	Барилга, байгууламж, орон сууц	3 124 030 844,37	3 400 685 530,37
39202	Хуримтлагдсан элэгдэл	(117 496 865,38)	(219 227 929,28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	200 962 760,00	233 962 760,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81 826 636,58)	(104 585 193,38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	387 528 421,93	410 892 196,93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(207 554 296,30)	(248 289 087,58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	160 371 974,33	167 521 574,33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105 754 197,08)	(121 915 968,07)
39209	Зам, гүүрийн байгууламж	2 581 000 000,00	2 581 000 000,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(64 524 999,96)	(129 049 999,92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1 133 587 730,63	1 353 707 243,63
39215	Хуримтлагдсан элэгдэл	(704 825 443,78)	(782 898 934,85)
39217	Ном	11 012 996,00	11 012 996,00
393	Биет бус хөрөнгө	120 487 000,20	121 567 980,22
39301	Програм хангамж	3 958 050,00	5 640 250,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2 381 049,80)	(2 982 269,78)
39303	Бусад биет бус хөрөнгө	118 910 000,00	118 910 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	7 335 799 283,89	7 435 934 836,94



Хөлөнбуйр сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	95 555 282,23	31 931 690,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	95 555 282,23	31 931 690,00
413	Өглөг	95 555 282,23	31 931 690,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2 751 213,19	56 035,00
4136	Бусад өглөг	92 707 554,04	31 875 655,00
41361	Байгууллагад төлөх өглөг	90 640 106,47	31 796 155,00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	114 779,05	24 747,00
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	257 636,79	54 753,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7 240 244 001,66	7 404 003 146,94
51	Засгийн газрын хувь оролцоо	7 240 244 001,66	7 404 003 146,94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 501 544 898,27	1 501 544 898,27
512	Хуримтлагдсан үр дүн	4 699 162 838,32	4 862 921 983,60
51210	Өмнөх үеийн үр дүн	4 697 928 530,81	4 699 162 838,32
51220	Тайлант үеийн үр дүн	1 234 307,51	163 759 145,28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 039 536 265,07	1 039 536 265,07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7 335 799 283,89	7 435 934 836,94

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 468 613 878,60	2 796 009 821,83
11	ТАТВАРЫН ОРЛОГО	39 347 305,18	38 521 104,18
110	Орлогын албан татвар	16 345 734,18	30 227 149,18
1100	Хувь хүний орлогын албан татвар	16 345 734,18	30 227 149,18
